



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/128

Мандалговь

“Юу Би Жи” ХХК-тай гэрээ
байгуулах тухай


Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/55 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Эрдэнэдалай сум/-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Юу Би Жи” ХХК-тай 38,500,744 (гучин найман сая таван зуун мянга долоон зуун дөчин дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2.Батлагдсан зураг, төсвийн дагуу Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Юу Би Жи” ХХК-ны захирал (Х.Сонинхүү)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Эрдэнэдалай сумын Засаг дарга (Б.Лхагвамандал), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210534